



ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 04 сарын 29 өдөр

Дугаар A1159

Улаанбаатар хот


“Гадаадын иргэн, харьятын газрын албан хаагчид албан тушаалын цол олгох, хэрэглэх, хураах журам” батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 8 дугаар зүйлийн 8.4, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.15, 41.17 дахь хэсэг, Засгийн газрын 2024 оны "Журам батпах тухай" 160 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. "Гадаадын иргэн, харьятын газрын албан хаагчид албан тушаалын цол олгох, хэрэглэх, хураах журам"-ыг нэгдүгээр хавсралтаар, цолны загварыг хөрдүүгаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Гадаадын иргэн, харьяатын газрын албан хаагчдад цолны нэмэгдлийг зохих журмын дагуу тооцож олгохыг Санхүүгийн хэлтэс (Ж.Солонго), орон нутаг дахь газар, хэлтэс (З.Даваасурэн, Б.Батдулам, Л.Өлзийбат, А.Хуанбай, Б.Мөнхбат, Л.Төрхүү, Г.Батцэцэг)-т зөвшөөрсүгэй.

3. Энэхүү журмыг нийт албан хаагчдад танилцуулж, мөрдүүлж ажиллахыг төв болон орон нутаг дахь газар, хэлтсийн дарга нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлагын газар (И.Баатархүү)-т тус тус үүрэг болгосугай.



1-2400607



Гадаадын иргэн харьяатын газрын даргын
2024 оны 04 дүгээр сарын 29 ны өдрийн
А/153 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН АЛБАН ХААГЧИД АЛБАН ТУШААЛЫН ЦОЛ ОЛГОХ, ХЭРЭГЛЭХ, ХУРААХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага (цаашид “байгууллага” гэх)-ын албан хаагчийн албан тушаалын цол (цаашид “цол” гэх) нь эрхэлж байгаа албан тушаалын ангилал, зэрэглэлийг тодорхойлно.

1.2. Байгууллагын албан хаагчид албан тушаалын цол олгох, хэрэглэх, хураахтай холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.

1.3. Алба хаагчийг албан тушаалд томилсон, дэвшүүлсэн, бууруулсан, албанаас чөлөөлсөн тухай тушаалд цол олгох, хураахтай холбоотой зохицуулалтыг тусгана.

Хоёр. Албан хаагчийн цол

2.1. Энэ журамд заасан нөхцөл, шаардлагыг хангасан албан хаагчид Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.15-д заасан дараах цолыг олгоно:

2.1.1. Тэргүүн зөвлөх цолыг байгууллагын дарга-ерөнхий байцаагчид;

2.1.2. Эрхэлсэн зөвлөх цолыг газар, хэлтсийн даргад;

2.1.3. Ахлах зөвлөх цолыг хяналтын улсын ахлах байцаагч, ахлах мэргэжилтэн түүнтэй адилтгах албан тушаалд;

2.1.4. Зөвлөх цолыг хяналтын улсын байцаагч, мэргэжилтэн түүнтэй адилтгах албан тушаалд тус тус олгоно.

Гурав. Албан хаагчид цол олгох

3.1. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.15.1-д заасны дагуу тэргүүн зөвлөх цолыг Хууль зүй, дотоод хэргийн сайд, эрхэлсэн, ахлах, зөвлөх цолыг Гадаадын иргэн, харьяатын газрын дарга тус тус олгоно.

3.2. Эрхэлсэн, ахлах, зөвлөх цолыг тухайн албан тушаалд жинхэлж томилогдсон албан хаагчид олгоно.

3.3. Төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлд томилогдсон албан хаагчид цол олгохгүй.

Дөрөв. Цол хэрэглэх

4.1. Ёслол албаны болон өдөр тутмын дүрэмт хувцасны зүүн энгэрт цолыг зүүж хэрэглэнэ.

4.2.Шар өнгийн цолны ялгах тэмдгийг ёслол албаны, мөнгөлөг өнгийн цолны ялгах тэмдгийг бусад төрлийн хувцсанд хэрэглэнэ.

4.3.Суурь пластик материалаар хийгдсэн цолны ялгах тэмдгийг зөвхөн өдөр тутмын урт, богино ханцуйтай цамц дээр хэрэглэнэ.

4.4.Албан хаагчийг албан тушаал дэвшүүлсэн, бууруулсан тохиолдолд тухайн албан тушаалын цолыг олгоно.

4.5.Албан тушаалын нэр, цолыг албаны үнэмлэх, албан бичиг, захидал харилцаа, өрөөний хаяг, нэрийн хуудас, хурал цуглаан, уулзалтын танилцуулгад хэрэглэнэ.

4.6.Албан хаагчийг нэгж хооронд шилжин, сэлгэн ажиллуулах тохиолдолд албан хаагчид олгосон албан тушаалын цолыг өөрчлөхгүй.

Тав. Цол хураах

5.1.Дараах тохиолдолд албан тушаалын цолыг Гадаадын иргэн, харьяатын газрын даргын тушаалаар хураана.

5.1.1.Албанаас чөлөөлөгдсөн;

5.1.2.Бусад төрийн байгууллагад сэлгэн болон шилжин ажилласан;

5.1.3.Хуульд заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн болон түр чөлөөлөгдсөн, халагдсан.

Зургаа. Хориглох зүйл

6.1.Албан хаагч нь дээд цолтой албан хаагчид хүндэтгэлтэй хандаж, өөрт олгогдоогүй цол хэрэглэхийг хориглоно.

6.2.Энэ журамд зааснаас бусад тохиолдолд албан хаагчид цол олгох, хэрэглэх, хураахыг хориглоно.

Долоо. Бусад зүйл

7.1.Цолыг дараах тохиолдолд олгохгүй:

7.1.1.Шагнал, урамшууллаар;

7.1.2.Туршилтын хугацаагаар ажиллаж байгаа;

7.1.3.Албан үүрэг түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байгаа.

7.2. Энэ журмыг зөрчсөн албан хаагчид холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлагыг хүлээлгэнэ.

Гадаадын иргэн харьяатын газрын даргын
2024 оны 04 дугээр сарын 29-ны өдрийн
11/39 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН АЛБАН ХААГЧДЫН АЛБАН ТУШААЛЫН ЦОЛНЫ ЗАГВАР, ХЭМЖЭЭ

1. Албан тушаалын цолны загвар нь:

- Байгууллагын лого;
- "IMMIGRATION" гэж латин үсгээр бичсэн байна;
- Цолны ялгах тэмдэг нь нэгээс дөрөв хүртэл босоо шугамтай байна.

Цол	Ялгах тэмдэг
Тэргүүн зөвлөх	Дөрвөн босоо шугам
Эрхэлсэн зөвлөх	Гурван босоо шугам
Ахлах зөвлөх	Хоёр босоо шугам
Зөвлөх	Нэг босоо шугам

- Цолны ялгах тэмдэг нь зүүн энгэрийн халаасны дээр 2мм-ийн зйтай байрлана. Албан хаагчийн овгийн эхний үсэг, нэр баруун энгэрийн халаасны дээр 2мм-ийн зйтай байрласан байна.
- Цолны ялгах тэмдгийн үндсэн хэмжээ:

Үсгийн фонт: Arial

Үсгийн хэмжээ: 25 pt

Үсгийн (бичиглэл) өнгө: шар болон мөнгөлөг

Шар болон мөнгөлөг өнгийн цолны ялгах тэмдгийн суурь даавуу материалын хэмжээ нь: 25 мм x 120 мм байх бөгөөд хатуулга нь зориулалтын нугарахгүй, хугарахгүй, сууринаас хялбар салахгүйгээр тогтоосон байна. (зураг 1, 2)





Логоны хэмжээ нь 17 мм диаметр, босоо шугамын өндөр 25 мм, өргөн 3 мм, IMMIGRATION бичгийн өндөр нь 16 мм, өргөн нь 68 мм, дээд доод захаас 6 мм зйтай, голчилж байрлана. Босоо шугам хоорондын зайд нь 2 мм байна.

Мөнгөлөг өнгийн цолны ялгах тэмдгийн пластик материалын хэмжээ нь: 25 мм х 90 мм байна. (зураг 3)

Байгууллагын логоны хэмжээ нь 17 мм диаметр, босоо шугамын өндөр 25 мм, өргөн 3 мм, IMMIGRATION бичгийн өндөр нь 13 мм, өргөн нь 44 мм, дээд, доод захаас 3 мм зйтай, голчилж байрлана. Босоо шугам хоорондын зайд нь 2 мм байна.

---оОо---





ЦОЛ ЯЛГАХ ТЭМДЭГ /ПЛАСТИК/

Зураг 3

